



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 102

Номгон

Хөрөнгө акталж, данснаас
хасах тухай

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2009 онд ашиглалтад орсон 7870,0 мянган төгрөгийн анхны үнэтэй элэгдлээ 100 хувь нөхсөн 94-88 БНА улсын дугаартай түргэн тусламжийн автомашины үнийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 27 дугаар тогтоолоор 50 хувиар бууруулан 400,0 мянган төгрөгөөр тогтоож, 2019 оны 07 дугаар сарын 17, 10 дугаар сарын 10-ны өдрүүдэд дуудлагын худалдааг 2 удаа зохион байгуулсан, Хот тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын хөрөнгөд бүртгэлтэй Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газарт ашиглагдаж байгаад 2014 онд шилжүүлж авсан 20,0 сая төгрөгийн өртөг бүхий Прадо маркийн 65-41 БНХ улсын дугаартай автомашины худалдах доод үнийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 71 дүгээр тогтоолоор 1,0 сая төгрөгөөр тогтоож, 2 удаа дуудлагын худалдаа зохион байгуулсан боловч оролцогч ирээгүй бөгөөд эдгээр автомашинуудыг цаашид ашиглах боломжгүй байгааг ТЭМДЭГЛЭЭД:

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын "а", 25 дугаар зүйлийн 25.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 40 дүгээр тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам"-ын 1.3, 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2009 онд ашиглалтад орсон 7870,0 мянган төгрөгийн анхны үнэтэй элэгдлээ 100 хувь нөхсөн 94-88 БНА улсын дугаартай түргэн тусламжийн автомашиныг, Хот тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын хөрөнгөд бүртгэлтэй 2014 онд шилжүүлж авсан 20,0 сая төгрөгийн

1190153

өртөг бүхий Прадо маркийн 65-41 БНХ улсын дугаартай автомашиныг тус тус акталж данснаас хассугай.

2. Актлагдсан тээврийн хэрэгслээс ашиглаж болох сэлбэгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл, Орон нутгийн өмчийн газрын хяналтан дор комисс томилон хүлээн авч, үнэлгээ, дүгнэлт гарган худалдан борлуулж, орлогыг Орон нутгийн өмчийн газрын төрийн сан банкны 100030051006, Хот тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 100030051425 тоот дансанд төвлөрүүлэхийг Нэгдсэн эмнэлэг, Хот тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын дарга нарт даалгасугай.

3. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д дор дурдсан ажлыг зохион байгуулахыг даалгасугай.


3.1. Актлагдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.2. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 11 дүгээр сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлэх;

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 27 дугаар тогтоолын хавсралтын автотээврийн хэрэгслийн хүснэгтийн 2 дахь мөр, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 71 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

5. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР